

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДУТНЭЛТ

2011 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Тамсагийн сав газар дахь “Тосон уул XIX”  
БХТ-тэй талбайн T19-28, T19-69-5, T19-55, T19-80  
блокуудын газрын тосны нөөцийн тайлан

Дорнод аймгийн нутаг дахь Тамсагийн сав газарт орших “Тосон уул XIX”  
Бүтээгдэхүүн хубаах гэрээт талбайн T19-28, Т 19-69-5, Т19-55, Т19-80 блокуудад  
ВНХАУ-ын хөрөнгө оруулалт бүхий “Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-ийн хийсэн  
хайгуульын ажлын үр дун, нөөцийн тооцооны тайлан болон түүнд шинжэч хийсэн  
M.Ариунбаяр /ахлагч/, Д.Алтанхуяг, А.Пүрэв, Т.Батжаргал, Х.Огтончимэг /нарийн  
бичгийн дарга/ нарын шүүмж, дүгнэлтийг ЭБМЗ-ийн ёргөгжсөн хуралдаанаар  
ХЭЛЭЛЦСЭН НЬ:


1. “Тосон уул XIX” Бүтээгдэхүүн хувваах гэрээт талбайн T19-28, Т 19-69-5, Т19-55,  
Т19-80 блокуудад хийсэн хайгуульын ажлын үр дун, нөөцийн тооцооны тайлан  
зохиогчид нь Ли Хонг-юинг (Li Hong-ying), Занг Гэ (Zhang Ge), Яан Бу-зэнг (Yang Bi-  
zeng), Зан Я-жин (Zhang Ya-jin), Оу Шиа (Ou Xia), Яант Зи-зэнг (Yang Zi-cheng) нар  
байна.
2. Дорнод аймгийн Тамсагийн сав газарт явуулсан хайгуулын ажлын үр дүнгийн  
тайланг 2010 оны 02 дугаар сарын 04 нийн өдрийн 06 дугаар хуралдаанаар хэлэлцэж  
Тосон-Уул XIX талбайн T19-24 блокийн баталгаат (proved) зэрэглэтийн газрын тос,  
тосонд ууссан хийн нөөцийг 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тоодон  
“Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-ийн тооцоолсноос Т19-20, Т19-22 дэд блокуудын  
нөөцийг хасч, мөн Тосон-Уул XIX талбайн T19-55, T19-X61-2, T19-7-1 блокууд болон  
T19-24 блокийн T19-20, T19-22 дэд блокуудад магадтай (probable) зэрэглэлийн газрын  
тосны геологийн нөөцийг тус тус Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн  
санд бүртгэсэн. Дээрх нөөцийг бүртгэхтэй холбогдуулан ЭБМЗ-ийн 2010 оны 02 дугаар  
сарын 04 нийн өдрийн 06 дугаар дүгнэлтэд дурьдагдсан хэлэлцэн асуудал давтагдсан.
3. Тосон-Уул XIX талбайнд 2009 онд бодсон 29 блокоос 11 блокийн зэрэглэлийг  
магадтай нөөцөд хэвээр үлдээж, харин **T19-28 блок** (T19-28, T19-46, T19-57 гэсэн 3 дэд  
блоктой), **T19-55 блок** (T19-55 гэсэн 1 дэд блоктой), **T19-69-5 блок** (T19-20, T19-52,  
T19-53, T19-67-2, T19-69-3, T19-69-5, T19-78, T19-120 гэсэн 8 дэд блоктой), **T19-80  
блок** (T19-7-1 /2 дэд блок/, T19-51-3, T19-80, T19-56, T19-62 гэсэн 6 дэд блоктой) 18  
блокуудын нөөцийг баталгаат зэрэглэдэд хамаарулсан байна.
4. Тосон-Уул XIX талбайн T19-28, T19-69-5, T19-55 болон T19-80 блокуудын  
“Геологийн баталгаат нөөц”/proved OOIP/ нь 60,060,800 тн буюу 452,957,200 баррель,  
“Тосонд ууссан хийн геологийн баталгаат нөөц”/Proved Original Dissolved Gas In Place/  
4,404 тэрбум шоо метр, “Тос агуулагч талбайн хэмжээ”/oil-bearing area/ нь 116.45 км<sup>2</sup>,  
газрын тосны “Ашиглалтын баталгаат нөөц”/Proved Recoverable Reserves/ нь 6,500,500  
тн буюу 49,028,210 баррель, “Тосонд ууссан хийн баталгаат ашиглалтын нөөц” нь 469  
сая м<sup>3</sup>-ээр тооцжээ.

5. Тосон-Уул XIX талбайн 2010-2029 онуудад төсөвлөсөн олборлолтын 36 орчим хувийг дээрх 4 блокоос олборлох ба энэ 4 блокийн төсөвлөсөн олборлолтын нийт хэмжээ 33,9 сая баррель, олборлолтын урьдчилсан мөнгөн орлого 2,426 сая ам.доллар, хайгуулын зардал 417 сая ам.доллар, хөрөнгө оруулант 580 сая ам.доллар байна. Сүүлийн 3 жилийн Дачин 33 Брентийн Унийт үндэслэн 1 баррель түүхий тосны борлуулах үнийг 71.3 ам.доллараар төлөвлөн, эрдийн түвшин (discount rate)-г -10 хувь байхад хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа (payback period) 8.9 жилийн дөгийн дотоод түвшин (internal rate of return) 10 хувь байна. Тосон-Уул XIX талбайн баррель тос олборлолтын өртөг 2010 онд 19.8 ам.доллар, 2011 ба 2012 онд 17.3 ам.доллар, 2013-2029 онд 12 ам.доллар болж 1 баррель түүхий тосыг 71.3 ам.доллараар борлуулахад олборлолт өдийн застгийн хувьд үр ашигтай байна. Олборлолтын хэмжээг зохицтой нэмэгдүүлэх замаар тос өгөмж (ashiiglaalтын түвшин) -ийг 20 хувь хүргэх боломжтой гэж үзсэн.

Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналын Үндсэн дээр хуралдааныг даргалагчийн зүтгэс хэлэлцэж буй асуудлаар ЭБМЗ-өөс гаргах дүгнэлтийн төслийн шийдвэрийн хэсгийг танилцуулж, санал хураахад шийдвэрийн төслийг хуралдаанд оролцсон санал өгөх 16 гишүүнээс 16 нь буюу 100% нь зөвшүөрсөн тул Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараах төслийн дагуу шийдвэр гаргахыг Эрдэс баялаг, эрчим хүчиний сайдад уламжлахаар тогтов. Үнд.

1. Тосон-Уул XIX талбайн T19-69-5 блокийн T19-20, T19-52, T19-53, T19-67-2, T19-78, T19-69-3, T19-69-5, T19-120 дэд блокууд; T19-55 блокийн T19-55 дэд блок; T19-80 блокийн T19-7-1, T19-51-3, T19-56, T19-80 дэд блокууд; T19-28 блокийн T19-28, T19-46, T19-57 дэд блокууд дахь газрын тосны геологийн баталгаат зэрэглэлийн нөөцийг 60,06 сая тонн (452,957,200 баррель), Үүнээс газрын тосны ашиглалтын нөөцийг 6,5 сая тонн (49,028,210 баррель); тосонд уссан хийн геологийн баталгаат зэрэглэлийн нөөцийг 4,4 тэрбум м<sup>3</sup>, Үүнээс тосонд уссан хийн магадтай (probable) нөөцийг 0,47 тэрбум м<sup>3</sup>-ээр тус тус Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд нэмж бүртгэх.
2. Тосон-Уул XIX талбайн дээрх нөөцийг баталгаат зэрэглэлээр нэмж бүртгэсэнтэй холбогдуулан 2010 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тушаалаар бүртгэгдсэн энэ ордын 74.54 сая тонн магадтай (probable) зэрэглэлийн нөөцийг 16,81 сая тонн, тосонд уссан хийн магадтай (probable) нөөцийг 0,33 тэрбум м<sup>3</sup> гэж шинэчлэн бүртгэх,
3. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Тосон-Уул XIX талбайд хайгуулын хугацаанд олборлосон газрын тосны хэмжээг 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тоодож нөөцийн хөдлөлгөөн хийж бүртгэхийг Газрын тосны газар, Ашигт малтмалын газарт хариуцуулах,
4. Геологи, структурын хувьд Тосон-Уул XIX талбайд тогтоогдсон Цагаанцав формациын T19-62 нөөцийн дэд блокийг Магад-ХХ талбайн тухайн хэсэгт (“Петромагад” ХХК) боломжтойг харгалзан Магад-ХХ талбайн тухайн хэсэгт (“Петромагад” ХХК) хайгуульян ажил хийгдэж дууссан тохицелд, Газрын тосны тухай хуулийн хүрээнд холбогдох журмаар (Хамтран ашиглах гэрээ-Unitization agreement) зохицуулах хүртэл дээрх блокод ашиглалт явулахгүй байхыг Газрын тосны газар болон “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д даалтая,

- Хайгуулын ажлын тайлан, холбогдох бусад материалууд, анхдагч материалууд (тухайлбал зураг зүсэлт, геофизикийн судалгааны ажлын тоон мэдээлэл, чөмтөн дээж, тосны физик, химийн шинжилгээний үр дун гэх мэт)-ыг нэг бүрчлэн Газрын тосны газарт хургуулэх шаардлагатай “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д даалгах, түүний хэрэгжилтэнд хяналт тавихыг Газрын тосны газарт хариуцуулах,
- Тосон-Уул ХХК талбайд нэмэлт хайгуул, туршилтын ажил явуулж баталгаат зэрэглэлийн ноөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг “Петрочайна Дачин Тамсаг”, ХХК-д даалгах,
- “Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 15 дугаар зүйлийн 1 дэх заалт, Тосон-Уул XIX гэрээт талбайд байгуулсан БХГ-ний 5.4 дүгээр заалтын “б”, хэсэг, 8.5 дугаар заалтын дагуу Тосон-Уул газрын тосны ордыг ашиглах техник, эдийн засгийн Үндэслэл /ТЭЗҮ/-ийг 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн болон энэхүү дүтнэлт дэх баталгаат зэрэглэлийн нөөцдөд тулгуурлан боловсруулах боломжтой гэж үзэх.



ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ЭБЭХЯ-НЫ  
ГЕОЛОГИЙН ВОДЛОГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Ө.ОЮУНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧИЙН ДАРГА

D. Altan ДАЛТАНХУЯГ